



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/249

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн салбарыг өндөржүүлсэн бэлэн
байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.21 дэх заалт, Дархлаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1. дэх хэсэг, Улсын Онцгой Комиссын 2025 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын хэмжээнд улаанбурхан өвчин тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан бэлэн байдлыг хангах, дархлаажуулалтыг эрчимжүүлэх зорилгоор эрүүл мэндийн салбарыг 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдрөөс 2025 оны 7 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан өөрийн байгууллагын хэмжээнд эм, эмнэлгийн хэрэгсэл, хүний нөөцийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын газар (Р.Гантуяа), бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. “Хаалганаас хаалганд” зарчмаар улаанбурхан өвчний эсрэг вакцинжуулалтад хамрагдвал зохих 10 сараас 15 насны хүүхдийн тоог нэгдүгээр, дархлаажуулалтын нэгдсэн төлөвлөгөөг хоёрдугаар, дархлаажуулах зааварчилгааг гуравдугаар, дархлаажуулалтыг зохион байгуулах ерөнхий зураглалыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.


4. Тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Э.Анхбаяр)-д, вакцины хамралтын тайланг долоо хоног тутам нэгтгэн Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газарт ирүүлэхийг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Э.Анхбаяр), Нийслэлийн эрүүл мэндийн газар (Х.Бат-Ирээдүй)-т тус тус үүрэг болгосугай.

5. Нөхөн дархлаажуулалтыг зохион байгуулахад резидент эмч, сувилагч нарыг дайчлан ажиллуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (М.Одгэрэл)-д, шаардагдах зардлыг шийдвэрлэн ажиллахыг Санхүү, эдийн засгийн бодлогын газар (Э.Мөнхсүх)-т, олон

141251398

нийтэд дархлаажуулалтын ач холбогдол, дархлаажуулалтын цэгийн үйл ажиллагааны талаар сурталчлан таниулахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Л.Баттөр), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Э.Анхбаяр), аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус даалгасугай.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

САЙД  Ж.ЧИНБҮРЭН

Эрүүл мэндийн сайдын
2025 оны 06 сарын 24 өдрийн
А/449-р тушаалын нэгдүгээр хавсралт

“ХААЛГАНААС ХААЛГАНД” ЗАРЧМААР УЛААНБУРХАН ӨВЧНИЙ ЭСРЭГ ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДВАЛ
ЗОХИХ 10 САРААС 15 НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО

№	АЙМАГ/ДҮҮРЭГ	10 сартайгаас -15 насны хүүхдүүдийн нөхөн дархлаажуулах, нөхөж шивэлт							VII/09-ний дотор нэмэлтээр дархлаажуулах 2025 оны 06-р сард 6-8 сартай ХЗХ тоо	Нийт ХЗХ тоо
		Хамрагдвал зохих хүүхдийн (ХЗХ) тоо	II/18-VII/22-ны хугацаанд хамруулсан			VII/09-ний дотор нөхөн дархлаажуулах ХЗХ тоо	VII/09-ний дотор нөхөж шивэх ХЗХ тоо	VII/09-ний дотор нөхөж шивэх, дархлаажуулах ХЗХ тоо		
			Нөхөж хийсэн	Нөхөж шивсэн	Дэд дүн					
1	Архангай	4819	516	2026	2542	52.7	1598	679	2277	2533
2	Баян-өлгий	10118	844	1585	2429	24.0	4294	3395	7689	8348
3	Баянхонгор	5517	510	999	1509	27.4	648	3360	4008	4359
4	Булган	3605	311	1611	1922	53.3	1065	618	1683	1806
5	Говь-алтай	3890	563	407	970	24.9	712	2208	2920	3112
6	Говьсүмбэр	664	84	258	342	51.5	64	258	322	414
7	Дархан-уул	7796	697	691	1388	17.8	295	6113	6408	6881
8	Дорноговь	4536	465	1213	1678	37.0	1534	1324	2858	3134
9	Дорнод	5184	314	1384	1698	32.8	75	3411	3486	3805
10	Дундговь	2898	837	712	1549	53.5	1000	349	1349	1485
11	Завхан	4055	271	1232	1503	37.1	1237	1315	2552	2818
12	Орхон	3809	351	856	1207	31.7	1026	1576	2602	3105
13	Өвөрхангай	6541	490	1283	1773	27.1	806	3962	4768	5193
14	Өмнөговь	5050	600	815	1415	28.0	1052	2583	3635	3949
15	Сүхбаатар	3994	670	1724	2394	59.9	513	1087	1600	1828
16	Сэлэнгэ	6925	500	1510	2010	29.0	765	4150	4915	5205
17	Төв	5404	374	1264	1638	30.3	998	2768	3766	3949
18	Увс	5464	434	1099	1533	28.1	1291	2640	3931	4338
19	Ховд	6586	635	770	1405	21.3	873	4308	5181	5589
20	Хөвсгөл	6390	263	1819	2082	32.6	2032	2276	4308	4785
21	Хэнтий	6142	363	1283	1646	26.8	1026	3470	4496	4762
22	Багануур	1941	292	328	620	31.9	701	620	1321	1426
23	Багахангай	348	7	116	123	35.3	50	175	225	254
24	Баянгол	25056	2458	2728	5186	20.7	11117	8753	19870	20674
25	Баянзүрх	27503	2310	2376	4686	17.0	6194	16623	22817	24397
26	Налайх	3032	149	192	341	11.2	335	2356	2691	2796

27	Сонгинохайрхан	20692	2758	3145	5903	28.5	2500	12289	14789	1239	16028
28	Сүхбаатар	14195	1168	1321	2489	17.5	933	10773	11706	543	12249
29	Хан-уул	20264	1992	2028	4020	19.8	8457	7787	16244	1283	17527
30	Цингэлтэй	8675	841	1880	2721	31.4	2628	3326	5954	466	6420
Нийт		231093	22067	38655	60722	26.3	55819	55819	114552	12798	183169



Эрүүл мэндийн сайдын
2025 оны 06 сарын 24 өдрийн
А/д-49-р тушаалын хоёрдугаар хавсралт

“ХААЛГАНААС ХААЛГАНД” ЗАРЧМААР УЛААНБУРХАН ӨВЧНИЙ ЭСРЭГ ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДВАЛ
ЗОХИХ 10 САРААС 15 НАСНЫ ХҮҮХДИЙН ДАРХЛААЖУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Аймаг/ Дүүрэг	Сум, өрхийн Эрүүл мэндийн төв	Тоо	Дархлааж уулалтын байнгын цэг	Дархлааж уулалтын явуулын цэг	Нийт дархлаажуу лалтын цэгийн тоо	Багийн гишүүди йн тоо	Хүйтэн хэлхээний бэлэн байдал, тоо				
								Шаардлагтай				
								Вакцин зөөврийн савны тоо	Хэм хяналтын хэрэгслэлийн н тоо	Мөсөн элементийн н тоо	Зөөврийн компьютер (вакцин тарьсан тухай бүр шивэлт хийнэ)	Интернет
1	Архангай	Сумын ЭМТ	18	19	5	24	120	34	56	448	28	28
Өрхийн ЭМТ		4										
2	Баян-Өлгий	Сумын ЭМТ	12	17	6	23	115	59	28	285	21	21
Өрхийн ЭМТ		4										
Тосгон		1										
Баг		1										
3	Баянхонгор	Сумын ЭМТ	20	24	3	27	135	85	74	456	24	25
Өрхийн ЭМТ		4										
4	Булган	Сумын ЭМТ	16	18	18	36	180	41	42	317	18	18
Өрхийн ЭМТ		2										
5	Говь-Алтай	Сумын ЭМТ	19	22	3	25	125	76	58	289	21	18
Өрхийн ЭМТ		3										
6	Говьсүмбэр	Сумын ЭМТ	2	3	4	7	35	16	13	114	5	5
Өрхийн ЭМТ		3										
7	Дорнод	Сумын ЭМТ	14	16	1	17	85	77	59	358	25	25

8	Дорноговь	Өрхийн ЭМТ	11	17	17	34	170	63	43	334	24	20
		Сумын ЭМТ	10									
		Өрхийн ЭМТ	8									
9	Дундговь	Сумын ЭМТ	15	17	17	34	170	57	47	127	18	18
		Өрхийн ЭМТ	2									
10	Дархан	Сумын ЭМТ	4	2	0	2	20	107	107	428	21	21
		Өрхийн ЭМТ	16									
11	Завхан	Сумын ЭМТ	24	26	8	34	170	95	63	321	28	11
		Өрхийн ЭМТ	3									
12	Орхон	Сумын ЭМТ	3	10	8	18	90	83	73	330	29	24
		Өрхийн ЭМТ	39									
13	Төв	Сумын ЭМТ	26	29	3	32	160	152	98	266	32	25
		Өрхийн ЭМТ	1									
14	Өвөрхангай	Сумын ЭМТ	18	21	6	27	135	74	73	522	23	23
		Өрхийн ЭМТ	4									
		Баг	2									
15	Өмнөговь	Сумын ЭМТ	14	17	23	40	200	98	64	265	23	23
		Өрхийн ЭМТ	3									
16	Сүхбаатар	Сумын ЭМТ	13	15	14	29	145	44	49	190	17	17
		Өрхийн ЭМТ	2									
17	Сэлэнгэ	Сумын ЭМТ	28	35	28	63	315	142	102	444	35	35
		Өрхийн ЭМТ	7									
18	Увс	Сумын ЭМТ	18	22	3	25	125	66	44	176	22	22
		Өрхийн ЭМТ	4									
19	Ховд	Сумын ЭМТ	17	22	2	24	120	96	58	466	25	29
		Өрхийн ЭМТ	5									
20	Хөвсгөл	Сумын ЭМТ	22	20	8	28	140	127	102	579	34	19
		Өрхийн ЭМТ	9									
21	Хэнтий	Сумын ЭМТ	26	28	5	33	165	47	39	146	20	19

		Өрхийн ЭМТ	4															
Дэд дүн			466	400	182	582	2920	1639	1292	6861	493							
22	Хан-Уул дүүрэг	Өрхийн ЭМТ	25	24	24	48	160	181	223	655	25							446
23	Баянзүрх дүүрэг	Өрхийн ЭМТ	39	39	39	78	390	39	39	400	39							48
24	Баянгол дүүрэг	Өрхийн ЭМТ	25	31	32	63	315	80		500	33							39
25	Сонгинохайрхан дүүрэг	Өрхийн ЭМТ	38	38	41	79	380	81	110	133	38							33
26	Чингэлтэй дүүрэг	Өрхийн ЭМТ																38
27	Сүхбаатар дүүрэг	Өрхийн ЭМТ	46	16	16	35	89											
28	Багануур дүүрэг	Өрхийн ЭМТ	3	3	3	6	12	6	10	15	3							3
29	Багахангай дүүрэг	Өрхийн ЭМТ	1	2	1	3	15	3	3	24	2							2
30	Налайх дүүрэг	Өрхийн ЭМТ	6	7	7	14	54	30	20	100	6							3
Дэд дүн			153	160	163	326	1415	420	292	1827	146							128
Нийт			619	560	345	908	4335	2059	1584	8688	639							574



Эрүүл мэндийн сайдын
2025 оны 06 сарын 24 өдрийн
А/244-р тушаалын гуравдугаар хавсралт

“ХААЛГАНААС ХААЛГАНД” ЗАРЧМААР УЛААНБУРХАН ӨВЧНИЙ ЭСРЭГ ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДВАЛ
ЗОХИХ 10 САРААС 15 НАСНЫ ХҮҮХДИЙГ ДАРХЛААЖУУЛАХ ЗААВАРЧИЛГАА

	Үйл ажиллагаа	Аргачлал	Хариуцах албан тушаалтан
1. Заавал хийх үндэсний товлолын дагуу 9 сар, 2 настай УГУ (Улаанбурхан, гахай хавдар, улаанууд) вакцинаас хоцорсон хамрагдвал зохих хүүхдийг тодорхойлох			
1.1	Сум, өрхийн ЭМТ-ийн эмч нар 10 сараас 15 насны хамрагдвал зохих хүүхдийн судалгааг хүүхдийн нэгдсэн бүртгэл, өрхийн бүртгэлээс хүүхэд тус бүрээр гаргах	Сум, өрхийн ЭМТ-ийн 0-15 насны хүүхдийн хүүхдийн нэгдсэн бүртгэл, өрхийн бүртгэлийн маягаас шүүнэ. • 10 сараас 15 насны бүх хүүхдээс товлолын дагуу улаанбурхан агуулсан вакцины 1 тунтай эсвэл хамрагдаагүй хүүхдийг тодорхойлж хамрагдвал зохих хүүхдийн (ХЗХ) тоонд оруулна	Сум өрхийн ЭМТ-ийн баг хэсэг хариуцсан эмч, сувилагч, нийгмийн ажилтан
1.2	Дархлаажуулалтын бичил төлөвлөгөө, зураглал гаргах	ХЗХ-ийн тоонд үндэслэн байнгын болон явууллын цэгээр дархлаажуулах, бичил төлөвлөгөөг өдөр өдрөөр гаргаж, зураглал гаргах	Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, эмч, сувилагч Дүүрэг, сум, хорооны Засаг дарга, хорооны хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан
1.3	Цахим программд нөхөн шивэх	• Хэрэв тухайн хүүхэд товлолын дагуу УГУ I, II тунд хамрагдсан бичиг баримттай бол хүүхдийн мэдээллийг дархлаажуулалтын цахим бүртгэлийн программ https://health.gov.mn/ эргэмжээр шивж оруулна	Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, эмч, сувилагч Дүүрэг, сум, хорооны Засаг дарга, хорооны хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан

1.4	Хаяг тодорхойгүй хүүхдийн бүртгэлийг харьяа хорооны иргэний бүртгэлийн мэдээлэлтэй тулган тодруулах	- Хаяг тодорхойгүй хүүхдийн бүртгэлийг харьяа хорооны иргэний бүртгэлийн мэдээлэлтэй тулган тодруулах - Шилжиж ирсэн болон түр оршин сууж байгаа хүүхдийн бүртгэлийг хамрагдвал зохих 0-15 насны хүүхдийн бүртгэл дээр нэмж бүртгэх.	Өрх, сумын ЭМТ-ийн дарга, Баг хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан, улсын бүртгэлийн мэргэжилтэн
1.5	2025 оны 6 дугаар сард 6-8 сартай хамрагдвал зохих хүүхдийн судалгааг хүүхдийн нэгдсэн бүртгэл, өрхийн бүртгэлээс хүүхэд тус бүрээр гаргах	2025 оны 06 дугаар сард 6-8 сартай хүүхэд хамрагдвал зохих хүүхдийн тоонд орно.	Сум өрхийн ЭМТ-ийн баг хэсэг хариуцсан эмч, сувилагч, нийгмийн ажилтан
Хоёр.Дархлаажуулах үйл ажиллагаа			
2.1	10 сараас 15 насны хүүхэд бүрийн УГУ вакцины I,II тунд хамрагдсан эсэхийг нягтлан, хоцорсон хүүхдийг нэгтгэн гаргах	УГУ вакцины I, II тунд хамрагдсан эсэхийг нягтлахдаа дархлаажуулалтын цахим бүртгэл, сар бүрийн хамралтын анхан шатны бүртгэл маягт хоцорсон хүүхдийг нэгтгэн гаргах	Сум өрхийн ЭМТ-ийн баг хэсэг хариуцсан эмч, сувилагч, нийгмийн ажилтан
2.2	Хамрагдвал зохих хүүхдийн тоонд үндэслэн шаардлагатай вакцин, дагалдах хэрэгслийг ЭМГ, ЭМТ-өөс татан авах	Эрүүл мэндийн сайдын 2011 оны 122 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Вакцин биобэлдмэлийг хүлээн авах, тээвэрлэх, хадгалах явцад баримтлах журам”-ыг мөрдөн ажиллах	Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, вакцинатор сувилагч
2.3	“Хаалганаас хаалганд” зарчмын дагуу 10 сараас 15 насны	Байнгын цэг болон явууллын дархлаажуулалтын багаар	Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, эмч, сувилагч

	хүүхдийн нөхөн дархлаажуулалтыг бичиг баримтгүй, вакцинд хамрагдсан эсэх нь тодорхойгүй хүүхэд байвал нөхөн дархлаажуулах	Ажлын өдрүүдэд 08:30-21:00 цаг хүртэл Амралтын өдрүүдэд 10:00-18:00 цагуудад ажиллах явуулын дархлаажуулалтын үед унаагаар хангах асуудлыг Засаг дарга аймаг, дүүрэг, сумын УОК зохицуулж, дэмжиж ажиллах Хүүхдийг дархлаажуулахын өмнө эмчийн үзлэг хийж, улаанбурханы эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн тохиолдол байвал хариу арга хэмжээний багт мэдээлж, голомтын дархлаажуулалтыг зохион байгуулах	Дүүрэг, сум, хорооны Засаг дарга, хорооны хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан
2.4	Дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн мэдээллийг цахим бүртгэлийн программд тухайн өдөр шивэх	Дархлаажуулалтын цахим бүртгэлийн программ https://vis.health.gov.mn/ -д шивж оруулах	Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, эмч, сувилагч
2.5	Вакцины чанар, аюулгүй байдал, тээвэрлэлт, хадгалалт, дархлаажуулалтын явцад дотоод хяналтыг хийж ажиллах (УГУ вакцин нь дулаанд мэдрэг вакцин тул задалсан вакцины журмыг мөрдөн ажиллах)	Эрүүл мэндийн сайдын 2011 оны 122 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт “Задалсан вакциныг хэрэглэх журам”-ыг баримтлан вакциныг найруулсан даруйд он, сар, өдөр, цаг, минутыг тэмдэглэн 6 цагийн дотор хэрэглэж буйд хяналт тавих	Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, эмч, сувилагч
2.6	Дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн дунд ДДУХ-ийн идэвхтэй тандалтыг харьяа сум, өрхийн эрүүл мэндийн төв хийх, яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангаж ажиллах	Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/527 дугаар тушаалын дагуу ДДУХ-ийн сэжигтэй тохиолдол бүрийг 24 цагийн дотор яаралтай мэдээлж, Эрүүл мэндийн сайдын 2012 оны 217 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/278 дугаар тушаалын дагуу хариу арга хэмжээг цаг алдалгүй шуурхай зохион байгуулах	Аймгийн ЭМГ, Дүүргийн ЭМТ-ийн Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга, Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн

Гурав.Тайлан мэдээ, дэмжлэгт хяналт, мэдээлэл сургалт сурталчилгаа			
3.1	Хамралтын мэдээг нэгтгэн гаргах, хяналт тавих	Дархлаажуулалтын хамралтын мэдээг өдөр тутам аймгийн ЭМГ, дүүргийн ЭМТ гаргаж мэргэжил арга зүйгээр ханган ажиллах	Аймгийн ЭМГ, Дүүргийн ЭМТ-ийн Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга, Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн
3.2	Дэмжлэгт хяналт	Дархлаажуулалтын нэгжүүдийн вакцины төлөвлөлт, вакцины чанар, аюулгүй байдал, тээвэрлэлт, хадгалалт, дархлаажуулалтын явцад дэмжлэгт хяналт хийх	Аймгийн ЭМГ, Дүүргийн ЭМТ-ийн Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга, Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн
3.3	Иргэд, олон нийтэд чиглэсэн мэдээ мэдээллийг тасралтгүй зохион байгуулах	Улаанбурхан өвчнөөс сэргийлэх болон нөхөн дархлаажуулалтын талаар мэдээллийг тогтмол өгч ажиллах	Аймаг, Нийслэлийн ЭМГ, Дүүргийн ЭМТ-ийн дарга, Дүүргийн ЭМТ-ийн Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга, Эрсдэлийн харилцааны хариуцсан мэргэжилтэн Сум хорооны нийгмийн ажилтан Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл

Эрүүл мэндийн сайдын
2025 оны 06... сарын 24 өдрийн
А/249-р тушаалын дөрөвдүгээр хавсралт

“ХААЛГАНААС ХААЛГАНД” ЗАРЧМААР 10 САРААС 15 НАСНЫ ХҮҮХДИЙГ УЛААНБУРХАН ӨВЧНИЙ ЭСРЭГ
ДАРХЛААЖУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЕРӨНХИЙ ЗУРАГЛАЛ

